

## ЛЮДВИГ ВИТГЕНШТЕЙНИЙ ФИЛОСОФИ: УТГЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ

Б.Мөнхжавхлан (Докторант)  
С.Бүжиглхам (Философи-IV анги)  
МУИС. НШУС.  
Философийн Тэнхим

**Түлхүүр үг:** хэл, эх хэл, практик хэл, утга, хэлэн тоглоом, ертөнц бол баримтуудын нэгдэл, үйлдлийн төлөв (*state of affairs*), утга хэрэглээ болох нь, зураглалын онол, хэлний хязгаар ертөнцийн хязгаар

Аналитик философийн хамгийн нөлөө бүхий философичдын нэг бол Л.Витгенштейн юм. Түүний Фрегегээс уламжлан авсан философи санаа хэлний философийн хувьд шинэ арга зүй, сэтгэлгээг бий болгосон төдийгүй хэл болон хэл шинжлэлийн философи, шинжлэх ухааны өөр олон салбарт Л.Витгенштейний философидолт аргагүйн чухал ач холбогдолтой байдаг.

Түүний философи үзлийн гол санааг энэхүү өгүүллийг бичигчид философийнх нь хамгийн чухал ойлголт болох “утга”-аар дамжуулан товч боловч илэрхийлэхийг эрмэлзсэн болно. Учир нь түүний үзэл баримтлал утга хэмээх ойлголтоос үүдэж тодорхой шилжилт хийсэн бөгөөд энэ нь суурь бүтээл болох “Логик философийн шастир”, “Философийн судалгаа” хэмээх бүтээлүүдэд илэрхий харагддаг. Түүнчлэн үгийн утга хийгээд хэрэглээнээс үүдэлтэй будлиан, үгнээс улбаатай төөрөгдөл зэрэг бидний өдөр тутмын эх хэлэнд тулгарч буй асуудлыг тодорхойлж, төөрөгдлийг олж “илрүүлэх” арга замыг илэрхийлсэн байдаг нь бусад философичидынхоос онцлог юм.

Үгийн утгыг мэднэ гэдэг нь тухайн үг ямар объектийг тэмдэглэж буйг, далд хийгээд зохимжтой санаа байна уу үгүй юу? зэрэг олон зүйлийг мэдэж байна гэсэн санааг агуулж байдаг. Энэ нь “Утга гэж яг юу вэ?”, “Утгыг хэрхэн ойлговол зохистой вэ?”, “Утгын тухай асуудал биднийг юунд хүргэж болох вэ?” гэдгийг олж тодруулах хэрэгцээг харуулж байна.

Л.Витгенштейн утгын тухай асуудлыг “Логик философийн шастир” зохиолдоо “Энэ номын зорилго бол бодол болон бодол бишийн хязгаарыг, бодлын илэрхийллээр дүрслэх явдал юм. Үүний тулд сэтгэгдэж болж байгаа зүйлийн хязгаарын аль аль талыг олох хэрэгтэй. (Өөрөөр хэлбэл бид сэтгэгдэж болохгүй байгаа зүйлийн талаар бодож үзэх боломжтой байх хэрэгтэй). Иймээс хэлэнд л хязгаарыг тогтоож болох бөгөөд хязгаарын нөгөө талд байгаа зүйлс нь утга учиргүй (*nonsense*) байх болно.”<sup>1</sup> хэмээн бичсэн байдаг. Өөрөөр хэлбэл Витгенштейн ертөнц, хэл, бодлын хязгаарыг олох буюу утгатай болон утга үгүй зүйлсийг ялгахыг зорьсон байна. Уг зорилгынхоо хүрээнд “хэл болон утгын тухай эргэцүүлээсээ урган гарсан метафизик системийг Витгенштейн хөгжүүлсэн байдаг”.<sup>2</sup> Иймээс ч Витгенштейнийхээр ертөнц бол баримтуудын нэгдэл<sup>3</sup>(1.1) төдийгүй логик орон зай дахь баримт(1.13) ажээ. Өөрөөр хэлбэл хүн ертөнцийг баримт буюу өгүүлбэрээр ойлгож авч тэдгээрийг дүрсэлж ухаардаг байна. Ингэхдээ өгүүлбэрийн хэлбэрээр дүрслэн мэддэг байна. Товчхондоо утга бүхий бодол болох өгүүлбэрээр бид ертөнцийг ухаарч байдаг юм.

1. Ludwig Wittgenstein. *Tractatus Logico-Philosophicus*. Translated by D. F. Pears and B. F. McGuinness. 2004., p 2.
2. George Pitcher. *The philosophy of Wittgenstein*. Prentice Hall of India, New Delhi. 1985., page 18.
3. ()-н дотор тэмдэглэсэн хэсгүүд нь Л.Витгенштейний “Логик философийн шастир”-аа дугаарласан өгүүлбэрүүдийн өмнөх дугаар болно.

Мөн түүнчлэн Витгенштейн логик орон зай хэмээн онцолж авсан нь баримтууд гэдэг бол бидний сэтгэхүй, бодолд байгаа зүйлс болохоос бус физик юм биш гэдгийг онцолсон хэрэг ажээ. Үйлдлийн төлөв (state of affairs) буюу объектуудын (юмсын) хослолыг баримт хэмээн тодорхойлдог учраас эдгээр нь мөн л адил логик орон зайд оршино. Нэрийн утга бол объект хэмээн тэрээр үзсэн байдаг агаад нэр болон өгүүлбэрийг тайлбарлах явцдаа утга болон утга холбогдлын тухай ойлголтуудыг харгалзуулжээ.

“Логик философийн шастир”-т “зөвхөн өгүүлбэр нь утга холбогдолтой(sense), өгүүлбэрийн гинжин хэлхээн дэх нэр нь утгатай(meaning)”(3.3) хэмээн бичсэн байдаг агаад, өгүүлбэрийн утга холбогдлыг дүрсэлж буй нөхцөлтэй нь уялдуулан авч үзсэн байдаг.

Харин нэрийн тухайд бид ямар утгатайг нь хэлж чадахгүй ч нэрийг өгүүлбэрт ашиглан тайлбарласанаар ямар утгатайг нь харуулж чадна. Энэ нь нэрийн утга нь өгүүлбэрт утга холбогдол оноох семантик үүргийг өөртөө хүлээдэг гэсэн үг. Өөрөөр хэлбэл нэрийн утга нь гадаад “хүчин зүйлээс” хамааралтай хэмээн Витгенштейн үзжээ. Жишээлбэл “Төгөлдөр” гэдэг үг нь ямар объектийг зааж буйг бид өгүүлбэрт байхад нь л мэдэж болно. Энэ нь хүний нэр, аль эсвэл бүрэн гүйцэд гэх мэт санааг илэрхийлсэн байж болох ч үйлдлийн төлөвт буюу өгүүлбэрт байгаа тохиолдолд нь уг үг нь ямар утгатайг мэднэ.

Тухайлбал “Жон Мэрид хайртай.” “Мэри Жонд хайртай” гэсэн өгүүлбэр байна. Энд ижилхэн нэр байгаа хэдий ч өөр өөр утга илэрч байна. Эндээс харахад өгүүлбэрийн логик бүтэц нь утга болон утга холбогдлыг илэрхийлэд чухал байдаг байна.

Мөн Витгенштейн тэмдэг хийгээд бэлгэдлийг утгыг илэрхийлэхтэй холбон авч үзсэн байдаг. Тэмдэг гэдэг бол бэлгэдлээр мэдрэгддэг (3.32) зүйл ажээ. Иймээс нэг ижил тэмдэг нь өөр өөр бэлгэдэл байж болох аж. Жишээлбэл “Хар бол хар” гэдэг өгүүлбэрт байгаа хар гэдэг үгс нь хоёр өөр утгатай төдийгүй хоёр өөр бэлгэдлийг илэрхийлжээ. Түүнийхээр төгс-тэмдэгтийн хэлэнд бид өгүүлбэрийг илэрхийлэхийн тулд тэмдэг болон хувьсагчийг ашигладаг тул энд утгын тухай төөрөгдөл гардаггүй аж. (3.325) Харин эх хэлний үгс нь бүдэг бүрхэг утгатай байдгаас болж эндүүрэл будлиан гардаг аж. Улмаар философийн үүрэг бол эх хэлээр бүрхэг болсон өгүүлбэрийн логик бүтцийг тодруулах, харуулах ёстой гэсэн санааг илэрхийлжээ. Иймээс ч Витгенштейн нэрнээс илүүтэй өгүүлбэрийг онцолж авч үзсэн байдаг.

Логик философийн шастир дахь утга болон утга холбогдлын тухай санаа нь семантикийн хөгжилд чухал хувь нэмрээ оруулсан юм. Энэ нь логик тогтмол нь ямар нэгэн зүйлийг илэрхийлдэг гэдэг санааг үгүйсгэж, өгүүлбэр болон нэрийн хоорондын зөрөөг илэрхийлж, хэлний хэрэглээний ач холбогдлыг чухалчилснаар илэрдэг байна.

Харин хожим нь Л.Витгенштейн “Философийн судалгаа” зохиолдоо утга болон хэлний хэрэглээний хоорондын асуудлыг судалсан байдаг. “Логик философийн шастир”-т хэл болон ертөнцийн харилцааг зураглалын онолоор тайлбарласан бол энд практик хэлний хэрэглээний асуудлыг авч үзсэн байдаг. Тэр ч утгаараа уг бүтээл нь анхан үеийн Л.Витгенштейн өөрийн үзэлд шүүмжлэлтэй хандаж, хэлний асуудлыг дахин боловсруулсны үр дүн юм.

Витгенштейн хэл нь яг л багажны хайрцаг мэт. Үг нь хэлний багаж бөгөөд, хэлийг хэрхэн ашиглаж буйгаас хамааран олон янзаар хэрэглэгддэг гэж үзсэн нь уг зохиолын гол тулгуур санаануудын нэг юм. Ер нь ч түүний философи арга зүй багажны хайрцагаар төсөөлөгддөг билээ. Тиймээс үгийн утга нь хэрэглээнээс шалтгаалдаг ажээ.

Витгенштейн утга бол хэрэглээ болох нь гэдгийг онцолсонтой уялдуулан хэлэн тоглоомын асуудлыг томъёолсон байдаг. Хэл болон түүнийг ашиглаж буй хүний үйлдэл нь хэлэн тоглоом юм. Үг нь хэлэн тоглоомд хэрхэн хэрэглэгддэгээсээ шалтгаалан өөр өөр утгатай байж болдог байна. Хүмүүс өөр өөр дүрэм үйлчилдэг, тус тусдаа хэлний тоглоомуудыг өдөр тутмын амьдралдаа хэрэглэдэг байна. Энэ ч утгаараа хэлэн тоглоом гэдэг бол Витгенштейний томъёолсон амьдралын хэлбэрийн нэгээхэн хэсэг юм. Өөрөөр хэлбэл хэл гэдэг бол амьдралын хэлбэр ажээ. Амьдралын хэлбэрийг бид соёл, нийгэм, түүх, орчин нөхцөл, бүрэлдэхүүн зэргээсээ хамааран өөрчлөгдөж болох хэдий ч энэ нь хүн төрөлхтний хувьд нийтлэг байдаг зан

авир гэж ойлгож болно.

Витгенштейн хожмын үедээ ч мөн урьдын адил хэл болон ертөнцийн харилцааны асуудлыг “сорьсон” байдаг. Түүний судалгаа нь бид ямар нэг үг нь аль хэдийн бусад үгтэйгээ уялдаа холбоотой гэдгийг мэддэг, хэлзүйн бүтцийг ойлгосон байдаг болохоор ямар нэгэн зүйлийг нэрлэж, үгийг ашиглаж чаддаг гэдгийг илэрхийлсэн юм. Бид аль хэдийн тодорхой нэг хэлэн тоглоомтой дасал болчихсон, түүний дүрмийг ойлгоод хэрэглээд сурчихсан байдаг байна. Ийм учраас үгийн утга нь хэрэглээндээ байдаг гэдгийг анзаардаггүй аж. Дээр өгүүлсэн тайлбаруудыг нэгтгэн дүгнэвэл:

- Бид ямар нэгэн үгийг буруугаар ойлгож байгаа нь хэлний тоглоомд тухайн үг хэрхэн хэрэглэгдсэнийг ойлгоогүйн үр дүн байж болох ажээ. Өөрөөр хэлбэл “Бидний ойлгохуйд гардаг үндсэн асуудал бол бидэнд үгийг хэрхэн хэрэглэх талаар тодорхой заавар бүхий үзэл байдаггүй”-тэй холбоотой юм байна.

- Шатар, одон бөмбөг, хөлбөмбөг гэх мэт олон янзын тоглоом байдагтай адил хүмүүсийн хамаарлын хүрээ бүрт тохирох өөрийн гэсэн тоглоомын дүрэмтэй хэлэн тоглоомууд байдаг байна.

- Хэлийг тоглоомтой адилтгасан нь нэг талаараа хэл болон үйлдэл нь хоорондоо чухал холбоотой гэдгийг онцолсон байна. Тийм ч учраас хэлийг амьдралын хэлбэр хэмээн тодорхойлжээ.

- Хүмүүс үгийг “зөв” хэрэглэхийн тулд ямар хэлэн тоглоомыг тоглож буйгаа мэдэх ёстой аж. Өөрөөр хэлбэл хэлэнд дүрэм голлож байдаг гэдгийг ойлгох хэрэгтэй.

- Хэлэн тоглоомын тухай ойлголт нь хүний үйлдлийн хэлэлцээт (conventional) шинжийг илэрхийлдэг аж.

Эндээс харахад утга болон утга холбогдлын тухай ойлголтыг “Логик философийн шастир”-т ч, “Философийн судалгаа”-нд ч аль алинд нь дурдсан байдаг хэдий ч ялгаатай аргагүй, байр суурийг баримталсан байдаг нь ажиглагдаж байна хэмээн энэхүү өгүүллийг бичигчид үзсэн юм. Энэ нь Витгенштейний хэл, ертөнцийн харилцаа, философийн асуудлыг авч үзэж байсан үзэл нь өөрчлөгдсөний илрэл гэж үзэж болно.

Тодруулан үзвэл:

“Логик философийн шастир”-т өгүүлбэр нь ертөнцийн логик бүтцийг тусгадаг хэмээн үзэж, түүнийг баримттай, бүр цаашилбал ертөнцтэй адилтгасан байдаг учраас энд өгүүлбэрийн утгын асуудал чухал байр суурь эзэлдэг бол “Философийн судалгаа”-нд үгийн хэрэглээ, утгыг ойлгох нь “биднийг хавхнаас мултрахад” тусалдаг гэсэн санаа байдаг.

Хэл болон ертөнц хэмээх хоёр хүрээнд утга нь зураглалын харилцаагаар илэрдэг гэх үзэл анхан үеийн Витгенштейнд байдаг бол хожмын үед утга болон утга холбогдлыг хэлэн тоглоом хэмээх илүү хувирамтгай, олон талт, үйлдлийг онцолсон ойлголтоор дамжуулан илэрхийлжээ. Энэ нь анхан үедээ Витгенштейн хэл болон ертөнцийн харилцааг зураглалын онолын хүрээнд авч үзэж байсан бол хожмын үедээ хэл тэр дундаа эх хэлний асуудлыг онцлон авч үзэж, хэлийг тоглоомтой адилтгасны үр дүн юм. Гэхдээ хэл бол бидний харилцааны хэрэгсэл төдий гэж үзэх нь хангалтгүй гэх байр суурийг Витгенштейн тууштай баримталжээ.

Анхан үедээ Витгенштейн философийг өөрийн авч үзэж буй асуудлын хүрээнээс хальсан буюу баримтын ертөнц, бүр цаашилбал миний хэлний хязгаараас чанад байдаг гэсэн бол хожмын аргагүйгээс нь харахад философийг “хэлэн дотор багтааж” хэлэн тоглоом гэж үзжээ.

Хэдийгээр асуудлыг өөр аргагүй, байр сууринаас авч үзсэн ч түүний хоёр бүтээлд аль алинд нь залгамж чанар илэрдэг. Тухайлбал:

- *Хэлийг философийн оньсогын эх сурвалж болох тухай санаа:* “Логик философийн шастир”-т эх хэлний үг юуг илэрхийлж буй нь тодорхой биш байдаг төдийгүй хүмүүс хэлзүйн дүрмийг хэрэглэхдээ төөрөлддөг нь философийн асуудалд хүргэдэг гэж үзсэн бөгөөд хожим

нь ч эх хэлний уг шинж нь түүний баялаг агуулгын илрэл хэдий ч биднийг философийн ижил асуудал руу хөтөлдөг хэмээжээ.

- Уламжлалт философийн асуудлыг няцаасан нь: Философийн асуудалд хандах зөв хандлага нь Витгенштейнийхээр тэдгээрийг шийдэх гэж оролдох бус, асуудлыг тавьсан эхлэх цэгт нь хандах явдал юм. Тэгэх юм бол яг үнэндээ бидний философийн асуудал хэмээн нэрлэж байсан зүйлс нь философийн хувьд хуурамч асуудал байсныг бид мэдэх болно гэсэн санааг тэр дэвшүүлсэн байдаг.

- Философи бол тодруулга хийх үйл явц: Витгенштейн өөрийн философийг номлол бус үйл ажиллагаа болохыг онцолсон байдаг. Уламжлалт философийн онол нь тэмдгийн талаарх будлиан байдаг гэж үзсэн учраас тэрээр онолын эсрэг байр суурийг баримталсан байдаг. Түүнийхээр философи бол уг будлианы ээдрээг тайлах үйл явц байх ёстой ажээ.

- Мөн түүний философид бихевиорист хандлага ажиглагддаг. Энэ нь тэрээр сэтгэхүйг хэлтэй, дараа нь схемтэй адилтгасан байдгаар илэрдэг.

- Анхан үеийн үзэлдээ Витгенштейн солипсизмыг сурталчилсан агуулгыг илэрхийлдэг бол хожмын үедээ тэрээр бодгаль хэлний асуудлыг үгүйсгэснээр ондоо хүний ухамсрыг үгүйсгэсэн санааг дэвшүүлсэн байдаг.

Витгенштейнээс урд хэл шинжлэлийн асуудлыг өөрийн философидолтын төвд тавьсан олон философич байсан ч тэдгээрээс ялгаатай нь тэрээр анхан үедээ хэлийг метафизик утгатайгаар авч үзэн, эх хэлэнд логикийн үүднээс анализ хийсэн байна. Мөн өөрийн бүтээлийг шүүмжлэх замаар дараагийн “шинэ шатанд” гарсан философидолтыг бий болгож хэлийг тоглоомтой адилтган, энд гарч ирж буй дүрмийн гажуудал, үгийн хэрэглээтэй холбоотой төөрөгдлийг олж харж, засч цэвэрлэж байх үүргийг “философичидод” хэлж өгсөн зэрэг нь түүний философид оруулсан асар том хувь нэмэр ажээ.

#### АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Ц.Гомбосүрэн. Хэл болон хэл шинжлэлийн философи. УБ. 2010
- Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ хот. 1966
- Ц.Гомбосүрэн. Шинжлэх ухааны философийн позитивист ба постпозитивист чиглэлүүд. УБ. 2004
- Р.П.Вольф. Философийн тухай. УБ. 2002 \George Pitcher. The philosophy of Wittgenstein. Prentice Hall of India New Delhi. 1985
- Ray Monk. *Ludwig Wittgenstein: The Duty of Genius*. London. 1991
- Ludwig Wittgenstein. *Tractatus Logico-Philosophicus*. Translated by D. F. Pears and B. F. McGuinness. 2004
- Ludwig Wittgenstein. *Tractatus Logico-Philosophicus*. Translated by C. K. Ogden. 2010
- L. Wittgenstein, *Philosophical investigation*. Translated by G. E. M. Anscombe. Basil Blackwell. 1963

#### Цахим эх сурвалж:

- <http://www.iep.utm.edu/wittgens/>
- <http://plato.stanford.edu/entries/wittgenstein/>

#### SUMMARY

The well known analytic philosopher in the twentieth century, Ludwig Wittgenstein says that 'the limits of my language mean the limits of my world. From this key statement and concept of meaning, authors of the article concluded that Ludwig Wittgenstein set out to show mapping language that describes the limits of the reality. Through his philosophy of language, we can identify the boundaries of philosophical thought based on his writings.